

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
/Д.МӨНХСАЙХАН/

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
/Ц.ИДЭРМӨНХ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022 оны 01 дүгээр сарын 03

Номгон

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариу-цах нэгж
0	1	2	3	4	5	6	7
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих.							
1.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ	Сонингийн урилга 25.000, Бичиг хэргийн зардал 10.000	Баянхонгор аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20 нэр төрлийн 86.7 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.	2021 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн 25,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалтаар 10 нэр төрлийн 900 сая төгрөгийн	Улсын төсвөөр санхүүжигдэх эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнүүдийн тендер сонгон шалгаруулалтыг нэгдүгээр улиралд багтаан цахимаар зохион байгуулж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан байна.	1-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
				хөрөнгө оруулалт нэмэгдэж нийт 22 нэр төрлийн 26,7 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг цахимаар 100% зохион байгуулсан.			
1.2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ	Сонингийн урилга 25.000, Бичиг хэргийн зардал 10.000	Баянхонгор аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 2,8 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн	2021 оны жилийн эцсийн байдлаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаар 15 нэр төрлийн 2,6 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж нийлүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийн тендер сонгон шалгаруулалтыг Эхний хагас жилд цахимаар зохион байгуулж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан байна	1,2-р улиралд	ОНӨГ
1.3	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ	Сонингийн урилга 25.000, Бичиг хэргийн зардал 10.000	Баянхонгор аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 28 нэр	2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн оруулалтаар 16 нэр төрлийн 1,1 тэрбум төгрөгийн	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийн тендер сонгон шалгаруулалтыг 1-3-р улиралд цахимаар зохион байгуулж, шалгарсан	1,2,3-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
			төрлийн 4,2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.	хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахимаар 100% зохион байгуулж нийлүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.	оролцогчтой гэрээ байгуулсан байна.		
Зорилт 2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, эрх зүйн актуудын хэрэгжилт, өмч хувьчлалыг зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, хяналт тавих, өмчийн хадгалалт хамгаалалт түүний үр ашгийг дээшлүүлэх.							
2.1	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлэх.	-	2022 оны 1-р улиралд багтаан "Гүүр софт" ХХКомпаний гаргасан хөрөнгийн бүртгэлийн програмыг ашиглан 4 байгууллагын үндсэн хөрөнгүүдийг QR кодтой болгон хөрөнгө тус бүрийг нэг бүрчлэн зургаар баталгаажуулна.	-	Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, сайжирна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
		-	Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглалтгүй барилга байгууламж, тээврийн хэрэгсэлийн чанар, ашиглалтын байдалд шинжилгээ хийж эдийн засгийн эргэлтэд оруулах, бүртгэлээс хасах, шилжүүлэх, худалдах үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгана.	2021 оны 11 сард явуулсан судалгаагаар 41 байгууллагын 3,1 тэрбум төгрөгийн барилга байгууламж, 36 байгууллагын 644 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл ашиглалтгүй байна.	1.Барилга байгууламж, тээврийн хэрэгслийн дутагдалтай орон нутгийн өмчит байгууллага, үйлдвэрийн газруудад балансаас балансад шилжүүлэх. 2.Худалдан борлуулах боломжийг эрэлхийлэн Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх. /дуудлагын худалдаа, уралдаант шалгаруулалтаар/ 3.Цаашид ашиглалтын шаардлага хангахгүй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан барилга	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
					байгууламжуудыг акталж данснаас хасах.		
2.2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмч шинээр олж авах, хувчлах, худалдах актлах, шилжүүлэх, эзэмшигч тогтоох, барьцаалах, дуудлагаар худалдах		2022 онд хөрөнгийн талаар гарсан тогтоолын хэрэгжилтийг хангуулж хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг 2022 оны санхүүгийн тайланд 100% тусгуулах; -Орон нутгийн өмчит 240 байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг холбогдох хуулийн дагуу байгуулсан эсэх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны тайлан, 2022 оны төлөвлөгөөнд хяналт тавих;	2021 онд орон нутгийн өмчийн талаар байгууллагууд хөрөнгөтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлэн тухай бүрд нь тогтоол, шийдвэр гаргуулж хэрэгжилтийг хангуулан биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлсэн. -Орон нутгийн өмчит 242 байгууллагатай холбогдон гарсан захирамж, тогтоол шийдвэрийн талаар байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг холбогдох мэдээллээр хангаж ажилласан.	Хагас, бүтэн жилд: Орон нутгийн өмчит 240 байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг холбогдох хуулийн дагуу байгуулсан эсэх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны тайлан, 2022 оны төлөвлөгөөнд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангасан байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас 2022 онд хөрөнгөтэй холбоотой гарсан тогтоолын хэрэгжилтийг гаргаж, орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг 2021 оны санхүүгийн тайлан балансад 100% тусгуулж нэгтгэлийг 2022 оны 03 дугаар сарын 20-ны дотор ТӨБЗГ-т хүргүүлэх. 2021 онд Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмч шинээр олж авах, хувчлах, худалдах актлах, шилжүүлэх, эзэмшигч тогтоох, барьцаалах, дуудлагаар худалдах хөрөнгийн талаар АИТХХ-ны тогтоол гаргуулан тогтоолийн хэрэгжилт 100% биелэсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
	Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах, дүнгийн мөрөөр авах		Хөрөнгийн тооллого, үр дүнгийн нэгтгэлд хамрагдах орон нутгийн хуулийн этгээдийн тоо	Орон нутгийн өмчит 240 хуулийн этгээдийг тооллого хийх арга зүйгээр хангасан.	Эхний хагас жилд: Орон нутгийн өмчит 240 хуулийн этгээдийн 2021 оны санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг хүлээн авч		

0	1	2	3	4	5	6	7
2.3	арга хэмжээний хэрэгжилтийг хангах.	5,0 сая төгрөг	Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн аймгийн нэгтгэсэн дүнг гаргаж, танилцуулсан эсэх. Нэгтгэлийг гаргаж ТӨБЗГ-т хүргүүлж улсын дүн мэдээнд нэгтгүүлсэн байх.		нэгтгэсэн байна. Жилийн эцэст: Тооллогын нэгдсэн дүн, дүгнэлтийг боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулсан байна. Улсын нэгдсэн дүнд тусгагдсан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
2.4	Орон нутгийн өмчийн 240 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газар үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг тухайн он дуустал "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д шивж оруулна.		"Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д 240 байгууллагын мэдээллийн баяжилт хийгдсэн байна.	Нийт 240 байгууллагын орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж мэдээллийн санг баяжуулж бүртгэлээр хяналт тавьж ажилласан.	Эхний хагас жилд: Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д 240 байгууллагын мэдээллийн дүүргэлт эхний хагас жилд 50 хувьтай хийгдсэн байна. - Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд орон нутгийн өмчит байгууллагуудын балансад бүртгэгдсэн үндсэн хөрөнгүүдийн тулгалт хийгдэж нэгдсэн дүн баталгаажсан байна. Жилийн эцэст: Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д орон нутгийн өмчит байгууллагуудын балансад бүртгэгдсэн үндсэн хөрөнгүүдийн тулгалт хийгдэж нэгдсэн дүн баталгаажсан байна. 240 байгууллагын хөрөнгийн 2021 оны хөдлөл өөрчлөлтийг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д 100 хувь шивүүлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
2.5	Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглаж буй этгээдтэй өмч эзэмшлийн гэрээ байгуулах, 2021 оны гэрээ дүгнэх хэрэгжилтэд хяналт тавих.	Бичиг хэргийн зардал 200,0 төгрөг	“Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”г баталгаажуулсан хуулийн этгээдийн тоогоор -195 2021 онд орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” болон хуулийн этгээдийн тоогоор -242	2021 онд орон нутгийн өмчит 195 хуулийн этгээдийн “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”г байгуулж 2022 оны хэрэгжилтийг дүгнэж, гэрээг сунгасан.	Эхний хагас жилд: Гэрээний сунгалт 6 дугаар сард дуусна. Жилийн эцэст: “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”г дүгнэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж орон нутгийн өмчит 195 байгууллагын гэрээг баталгаажуулан хуулийн этгээдэд хүргүүлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
2.6	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх. Төлөвлөлтийн уялдаа: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 21/01 дугаар тогтоолоор батлагдсан журам		2022 оны байгууллагуудын түрээсийн гэрээг хянан батлаж, түрээслэсэн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалт, түрээсийн төлбөр төлөлт, түрээсийн гэрээний, хэрэгжилтэд хяналт тавих.	2021 онд 16 түрээсийн гэрээ байгуулж орон нутгийн төсөвт түрээсийн орлого 16 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	Жилийн эцэст (өссөн дүн): 2021 оны байгууллагуудын түрээсийн гэрээг хянан баталж, түрээслэсэн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалт, түрээсийн төлбөр төлөлт, түрээсийн гэрээний, хэрэгжилтэд хяналт тавьж түрээсийн орлогыг орон нутагт төвлөрүүлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
2.7	Орон нутгийн өмчийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавьж, өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг бууруулах		- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрөл; АИТХТ-дийн шийдвэрийн төсөл, танилцуулга боловсруулсан байх.	- Орон нутгийн өмчит 83 хуулийн этгээдийн 587 автомашины тоо, төрөл болон зардлын судалгааг 2020 оны санхүүгийн жилээр гаргасан.	2021 оны санхүүгийн тайлан тэнцэл нэгтгэгдсэний дараа Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт ашиглалтанд байгаа автомашины зардлын судалгаа, мэдээллийг нэгтгэсэн байх.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
2.8	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа худалдан авалтыг гэрээний дагуу хүлээн авах, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, цахим мэдээллийн сан үүсгэх, удирдлагыг мэдээллээр хангах;		Шинээр ашиглалтад орсон барилгын тоо үнийн дүнгээр -Хөрөнгө хүлээн авах комисст орж ажилласан тоо -Засвар үйлчилгээ хийгдсэн барилга, нийтийн эзэмшлийн зам талбай тоог үзүүлэлт, үнийн дүнгээр -Шийдвэрийн тоо -Шийдвэрийн дагуу эзэмшигч тогтоож хөрөнгөд бүртгүүлсэн тоо хэмжээ үнийн дүн	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа худалдан авалтын гэрээний дагуу улсын комисс хүлээн авч ашиглалтанд орсон тухай бүрт нь шийдвэр гаргуулан хөрөнгүүдэд эзэмшигч тогтоон ажилласан.	Эхний хагас жилд: Хөрөнгө хүлээн авах комисст байнга орж ажиллах -Хөрөнгийг эзэмшигч байгууллагын дансанд бүртгэж "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д хөдлөл өөрчлөлтийг тухай бүр хийсэн байна. Жилийн эцэст: Удирдлагуудыг хөрөнгийн талаарх мэдээллээр тогтмол хангасан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
2.9	Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого, шийдвэрийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	Бичгийн цаас принтерийн хор өнгөт зургийн цаас.	Орон нутагт үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, олж авах, актлах, түрээслэх, бусдад шилжүүлэх, төрийн өмчид бүртгэлтэй хөрөнгүүдтэй холбоотой гарсан 3Г тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын холбогдох шийдвэр, Аймгийн ИТХ хурал, Засаг даргын баталсан шийдвэрүүдийг эмхтгэн орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад хүргүүлнэ.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XXI хуралдааны 2020 оны 21/01, 21/02 тогтоолоор нээлттэй дуудлагын худалдааны болон түрээсийн 2 журамд өөрчлөлт оруулсан.	Орон нутгийн өмч, хөрөнгөтэй холбоотой журмуудыг эмхтгэн гарын авлага ном санхүүгийн ажилтнуудын тоогоор гаргаж жагсаалтаар тараасан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ							
3.1	Улсын болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа оролцогчдыг буюу аж ахуйн нэгжүүдийг өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажиллах.		2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, урсгал төсвөөр, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 59 нэр төрлийн 93,7 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, урсгал төсвөөр, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 68 нэр төрлийн 32,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100% нээлттэй цахим хэлбэрээр зохион байгуулж, оролцогчдыг тэгш боломжоор хангасан.	Эхний хагас жилд: 2022 оны аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, урсгал төсвөөр, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр нээлттэй, оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажилласан байна. Жилийн эцэст: 2022 оны аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийг нээлттэй, цахим хэлбэрээр оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор хангаж тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байх ба шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулагдсан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
3.2	Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход шаардлагатай тоон гарын үсэг олгох.	Бичиг хэргийн зардал 200,0 төгрөг	2022 онд шинээр 50 тоон гарын үсэг олгох бөгөөд тоон гарын үсгийн сунгалтыг тогтмол хийхээр төлөвлөж байна.	2021 онд шинээр 65 ширхэг тоон гарын үсгийг аж ахуйн нэгжүүдэд олгосон. 25 аж ахуйн нэгж тоон гарын үсгийн хүчинтэй хугацааг сунгуулсан.	Жилийн эцэст: 2022 онд шинээр 50 тоон гарын үсэг олгох бөгөөд тоон гарын үсгийн сунгалтыг тогтмол хийнэ.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
3.4	Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход анхаарах зүйлс, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт явуулах.		Сангийн яам Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар зохион байгуулах цахим сургалтад орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байна.	Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ, ГХБХБГ, МХГ хамтран тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын удирдах ажилтан, инженер техникийн ажилчдыг оролцуулан барилгын салбарын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт оролцож барилгын салбарын аж ахуй нэгжүүдэд шаардлагатай мэдээллийг хүргэж ажилласан.	Сангийн яам Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар зохион байгуулах цахим сургалтад орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг тухай бүр хамруулна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
Зорилт 4. Орон нутгийн өмчийн харилцааны талаар аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ							
4.1	Орон нутгийн өмчийн 240 байгууллагын албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх.		- Сургалтын тоо; 4 - Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо; 100 - Сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулсан байх.	2021 онд аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн этгээдийн давхардсан тоогоор 260 гаруй албан хаагчдад өмчийн болон өмч хөрөнгөтэй холбогдон гарсан журмын талаарх сургалтыг 20 сум, бүх санхүүгийн албаны дарга нарт нийт 5 удаа хийж чадавхийг дээшлүүлсэн бөгөөд нийт 100 гаруй төрийн албан хаагчид болон ард иргэдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн.	Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтарч баталсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан байна; Зохион байгуулсан сургалтын тоо – 4 сум, Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо (давхардсан тоогоор)–100, мэргэжил, арга зүйгээр хангасан тоо – 110 удаа	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
Зорилт 5. Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжилтэй ажилтанд зориулсан үйлчилгээ							
5.1	Төсвийн байгууллага болон сумдад худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг эрх бүхий албан тушаалтанд Төрийн болон орон өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон холбогдон гарсан эрх зүйн акт цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар сургалт явуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.	Сургалтын цайны завсарлага 50.0 төгрөг	2022 онд төсвийн байгууллага болон сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтануудад 1 удаа сургалт зохион байгуулж. Мэргэжил арга зүйн зөвлөгөөг байнга өгч ажиллана.	2021 онд төсвийн байгууллага болон сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтануудад 3 удаа сургалт зохион байгуулсан ба дээрх ажилтануудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг утсаар болон team viewer-ээр холбогдон тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.	2022 онд Төсвийн байгууллага болон сумдад худалдан авах ажиллагааг хариуцсан эрх бүхий албан тушаалтануудад Төрийн болон орон өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон холбогдон гарсан эрх зүйн акт, цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар сургалтыг 1 удаа явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
5.2	Төсөвт байгууллагын албан тушаалтан, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөлүүдэд худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд орж ажиллах эрх бүхий АЗ гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулах.		2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэргэдэх сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран зохион байгуулдаг худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтыг 1 удаа зохион байгуулна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох А-3 сургалтыг цаг үеийн байдлаас шалтгаалан танхимаар зохион байгуулах боломжгүй байсан тул суралцах хүсэлтэй хүмүүсийг. Сангийн яам болон төрийн худалдан авах ажиллагааны газар, газрын дэргэдэх АЗ сургалт зохион байгуулах эрхтэй сургалт, зөвлөгөө өгөх төвүүдээс зохион байгуулж буй онлайн сургалтуудад тухай бүр холбож хамруулсан.	2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэргэдэх сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран зохион байгуулдаг худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтыг 1 удаа зохион байгуулсан байна.	4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль							
6.1	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааг төлөвлөх, 2021 оны худалдан авах ажиллагааг тайлагнах, зохион байгуулах, үр дүнг нийтлэх		Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл, төлөвлөгөөг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хуулийн цаг хугацаанд хүргүүлнэ.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл, төлөвлөгөөг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хуулийн цаг хугацаанд хүргүүлсэн.	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл, төлөвлөгөөг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хуулийн цаг хугацаанд хүргүүлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
6.2	Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн харилцааг зохицуулж, ТӨ, ТӨХ маягтаар гаргадаг тайлангуудын 2020 оны нэгтгэлийг нэгтгэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, улсын дүн мэдээ нэгтгэж хүргүүлэх.	Тээврийн зардал, томилолт	Захиргааны статистикийн маягтын дагуу мэдээлэл өгсөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо; Мэдээллийг нэгтгэн тайлагнасан эсэх.	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн болон захиргааны статистикийн маягтуудын дагуу орон нутгийн өмчит 241 байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, биет бус хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж, түүх соёлын дурсгалт зүйлийн	Эхний хагас жилд: Орон нутгийн өмчит 240 хуулийн этгээдийн өмчийн харилцааг зохицуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Жилийн эцэст: Орон нутгийн өмчит 240 хуулийн этгээдийн орон нутгийн өмчийн мэдээллийг нэгтгэж, хуулийн хугацаанд тайлагнан мэдээлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
				жагсаалтыг нэг бүрчлэн гаргаж мэдээ тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр цахимаар хүлээлгэн өгсөн.			
ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах							
7.1	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах		Төрийн албаны тухай хууль болон түүнтэй уялдан гарсан эрх, зүйн актыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.	Газрын дарга болон албан хаагчид нь Төрийн албаны тухай хууль болон түүнтэй уялдан гарсан эрх, зүйн актыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан.	Төрийн албаны тухай хууль болон түүнтэй уялдан гарсан эрх, зүйн актыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
7.2	"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллах.		Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг холбогдох хэлтэст хүргүүлж, хяналтанд авсан байх. http://bayankhongor.igovernment.mn/home/ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд мэдээллийг	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмын 3.2 дахь хэсэгт заасан баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг тухай бүр бодлогын хэлтэст /Санхүү, төрийн сангийн хэлтэст/ хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар http://bayankhongor.igovernment.mn/home/ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим	Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хагас жилийн болон жилийн эцсийн хэрэгжилтийг холбогдох бодлогын хэлтэст хугацаанд нь хүргүүлж, http://bayankhongor.igovernment.mn/home/ Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд мэдээллийг оруулсан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
			тогтоосон хугацаанд оруулсан байх.	системд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засаг даргын захирамж, албан даалгаварын жилийн эцсийн хэрэгжилтийг оруулж дээд шатны байгууллагаар үнэлүүлсэн.			
7.3	Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, түүний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах.		Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-д заасан хугацаанд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэх, батлуулах, үнэлүүлэх ажлыг зохион байгуулсан байх. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр сарын 5-ны дотор батлуулах. Хагас жилийн тайланг 6 сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайланг 12 сарын 15 дотор төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах, 12 сарын 25-ны дотор үнэлүүлэх.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 14-нд, жилийн эцсийн биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчид тус тус тайлагнасан.	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-д заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр сарын 5-ны дотор батлуулж, хагас жилийн тайланг 6 сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайланг 12 сарын 15 дотор төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж, 12 сарын 25-ны дотор үнэлүүлсэн байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэж, үнэлэх		Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө	Орон нутгийн өмчийн газрын төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг "Төрийн жинхэнэ албан хаагчийн	"Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн		

0	1	2	3	4	5	6	7
7.4	ажлыг зохион байгуулах.		боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-д заасны дагуу Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр сарын 10-ны дотор батлуулах, хагас жилээр 6 дугаар сарын 15, жилийн эцсийн байдлаар 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнах, хагас жилээр 6 дугаар сарын 17, жилийн эцсээр 12 дугаар сарын 17-20-ны дотор үнэлэх, мөн явцын ярилцлагыг 1,3-р улиралд хийх ажлыг тус тус зохион байгуулсан байх.	гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-д заасны дагуу 2021 оны 01 сарын 05-нд баталж, 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хагас жилийн биелэлтийг тайлагнах, үнэлүүлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 2021.12.09-ний өдрөөс 10-ны өдөр дүгнэж, үнэлэх ажлыг тус тус зохион байгуулсан.	түвшинг үнэлэх журам"-д заасны дагуу Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр сарын 10-ны дотор батлуулах, хагас жилээр 6 дугаар сарын 15, жилийн эцсийн байдлаар 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнах, хагас жилээр 6 дугаар сарын 17, жилийн эцсээр 12 дугаар сарын 17-20-ны дотор үнэлэх, мөн явцын ярилцлагыг 1,3-р улиралд хийх ажлыг тус тус зохион байгуулсан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ
7.5	Байгууллагын хүний нөөцөд орсон өөрчлөлтийг тухай бүр төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн системд оруулах, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах.		Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байх.	Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд байгууллагын албан хаагчдын 2018 оноос хойших үр дүнгийн үнэлгээг оруулж, бусад дутуу мэдээллийг нөхөж оруулсан. Мөн 2021 оны 12 сард нэг ажилтан шилжиж, түүний оронд шатлан дэвшсэн ажилтан, төрийн захиргаанд түр томилогдсон ажилтан, шинээр орсон ажилтантай холбогдох мэдээллийг хүний нөөцийн системд үнэн зөв, бүрэн оруулсан.	Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-д заасны дагуу төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд байгууллагын албан хаагчдийн мэдээлэлд жилийн эцсийн байдлаар орсон өөрчлөлтийг тухай бүр, бүрэн, үнэн зөв оруулсан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
7.6	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах		<p>Аймгийн 20 сум болон төсвийн байгууллагуудын 2022 оны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нийтлэнэ.</p> <p>20 сум болон төсвийн байгууллагуудын 2021 оны хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд шивж өндөрлүүлнэ.</p>	<p>2021 онд Аймгийн 20 сум, төсвийн 14 байгууллагын худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд шилжүүлсэн.</p> <p>20 сум болон төсвийн байгууллагуудын 2018, 2019 оны хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд шивж өндөрлүүлсэн.</p>	<p>Аймгийн 20 сум болон төсвийн байгууллагуудын 2022 оны төлөвлөгөө төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нийтлэгдсэн байна.</p> <p>20 сум болон төсвийн байгууллагуудын 2021 оны хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүрэн шивж оруулсан байна.</p>	1-р улиралд	ОНӨГ
7.7	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах	Сонинд урилга болон төлөвлөгөө нийтлүүлэх 1,8 сая төгрөг.	2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонинд байршуулан нийтлүүлнэ. Мөн 2022 онд зохион байгуулагдах нээлттэй дуудлагын худалдааны зарыг Баянхонгор телевиз болон холбогдох цахим хуудсуудаар байршуулан зарлана.	2021 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг өдөр тутмын Монголын Үнэн сонинд тус тус байршуулан нийтлүүлж, 2021 онд зохион байгуулагдсан нээлттэй дуудлагын худалдааны зарыг Баянхонгор телевиз болон холбогдох цахим хуудсуудаар байршуулан зарласан.	2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонинд байршуулан нийтлүүлнэ. Мөн 2022 онд зохион байгуулагдах нээлттэй дуудлагын худалдааны зарыг Баянхонгор телевиз болон холбогдох цахим хуудсуудаар байршуулан зарласан байна.	1,2,3,4-р улиралд	ОНӨГ

0	1	2	3	4	5	6	7
7.8	Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх.		Архив албан хэрэг хөтлөлтийн стандарттай холбогдох сургалтанд цаг тухай бүрт нь хамрагдаж, мэдлэг ур чадвараа хөгжүүлэн ажилласан байх.	2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй ажилтанг байгууллагын Архив, бичиг хэргийн эрхлэгчээр томилон ажиллуулж байгаа бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан ажилласан.	Архив албан хэрэг хөтлөлтийн стандарттай холбогдох сургалтанд цаг тухай бүрт нь хамрагдаж, мэдлэг ур чадвараа хөгжүүлэн ажилласан байна.	Эхний хагас жилд: 50 хувь, сүүлийн хагас жилд 100 хувь гүйцэтгэсэн байна.	ОНӨГ
7.9	"Цахим-Архив Баянхонгор" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах		2018-2019 оны байнга хадгалах цаасан суурьтай баримтыг Төрийн архивын тасагт шилжүүлнэ.	2013-2017 оны байнга хадгалах баримтыг Төрийн архивын тасагт цаасан болон цахим хэлбэрээр шилжүүлсэн.	2018-2019 оны цаасан суурьтай байнга хадгалах баримтыг Төрийн архивт шилжүүлсэн байна.	Эхний хагас жилд: 50 хувь, сүүлийн хагас жилд 100 хувь гүйцэтгэсэн байна.	ОНӨГ
7.10	"Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангах" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.		Байгууллагын 2023 оны төсөвт Архивын нягтруулсан шүүгээ авах санал өгөх мөн тусгай архивын өрөөтөй болох.	2021 онд байгууллагын архивын баримтын 85 хувь нь хамгаалалтын хайрцагтай болсон.	Байгууллагын 2023 оны төсөвт Архивын нягтруулсан шүүгээ авах санал өгөх мөн тусгай архивын өрөөтөй болсон байна.	Эхний хагас жилд 30 хувь, сүүлийн хагас жилд 100 хувь гүйцэтгэсэн байна.	ОНӨГ

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

№	Төлөвлөгөөний хавсралт
Хавсралт №1.	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын 2022 оны төлөвлөгөө
Хавсралт №2.	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө
Хавсралт №3.	Байгууллагын 2022 оны төсөв

БАТЛАВ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА  Ц.ИДЭРМӨНХ

2022 оны 01 сарын 02

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫГ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 01 дүгээр сарын 02

Номгон

№	Байгууллагын ажилчдад хэрэгцээтэй байгаа сургалтууд	Сургалт авах газар	Хэрэгцээ шаардлагатай албан хаагчид	Шаардагдах хөрөнгө
0	1	2	3	4
1	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтыг судлаж дуусгах	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	Л.Дуламсүрэн	Томилолт
2	Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт	Удирдлагын академи	Б.Бямбасүрэн Л.Дорждулам	Томилолт
3	Худалдан авах ажиллганы мэргэшүүлэх АЗ сертификатын сургалт	Төрийн худалдан авах ажиллагааны дэргэдэх АЗ сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагууд	Ц.Идэрмөнх С.Рэнцэнбямба Н.Энх-Амгалан Б.Цэрэнлхагва Р.Янжмаа М.Пүрэвдулам Б.Бямбасүрэн	Сургалтын зардал
4	Удирдлагын академийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт	Удирдлагын академи	Р.Янжмаа	Томилолт

0	1	2	3	4
5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Төрийн худалдан авах ажиллагааны газраас албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор зохион байгуулах онлайн, танхимын сургалтуудад тухай бүр хамрагдах	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Төрийн худалдан авах ажиллагааны газар	Байгууллагын бүх албан хаагчид	Томилолт


ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
МЭРГЭЖИЛТЭН



Р.ЯНЖМАА

БАТЛАВ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА *Ц.ИДЭРМӨНХ*

2022 оны *01* сарын *02*



БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


2022 оны 01 дүгээр сарын 02

Номгон

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	Ажилтан, албан хаагчдаа жилд нэг удаа багцын үзлэг шинжилгээнд хамруулах.	1-12 саруудад	Байгууллага /Дарга/	
2	Түлээ нүүрсний хөнгөлөлтийг жилд нэг удаа олгоно.	10-12 сард	Байгууллага /Дарга/	
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн, жилээр дүгнэж, урамшууллыг жилийн эцсээр олгоно.	12 сард	Байгууллага /Дарга/	
4	Ажилтнууд ажлын шаардлагаар өглөө эрт ирэх, оройтож тархад албаны унаагаар үйлчлэх.	1-12 саруудад	Байгууллага /Дарга/	
5	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг үнэлж, цалингийн шатлалыг ахиулна.	1-12 саруудад	Байгууллага /Дарга/	

1	2	3	4	5
6	Төрийн албан хаагчдыг орон сууцанд хамруулах төсөл хөтөлбөрт хамрагдуулах талаар дэмжлэг үзүүлж ажиллана.	1-12 саруудад	Байгууллага /Дарга/	
7	Өвлийн улиралд албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витаминжуулах ажлыг 2 удаа зохион байгуулна.	1-12 саруудад	Байгууллага /Дарга	
8	Ур чадвар, мэргэжил, мэргэшил дээшлүүлэхэд цалинтай чөлөө олгох дэмжлэг үзүүлнэ.	1-12 саруудад	Байгууллага /Дарга	
9	Нэмэгдэл авдаггүй ажилчдын цалингийн шатлалыг ахиулах.	1-12 саруудад	Байгууллага /Дарга	
10	Хүүхдийн баяраар албан хаагчдынхаа /0-16/ настай хүүхдүүдэд /20,0-25,0/-т бэлэг олно.	6 сард	Байгууллага /Дарга	
11	Ар гэрийн гачигдал тохиолдсон болон Төрийн зэрэглэлтэй одон медаль, цол тэмдэг авсан тохиолдолд /100,0-200,0/-ний тусламж шагнал олгоно.	1-12 саруудад	Байгууллага /Дарга	
12	Хамт олны нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүн бүрээс сар бүр 20,0 мянган төгрөгийн хураамж авч хамтын сан байгуулна.	1-12 саруудад	Л.Дуламсүрэн М.Пүрэвдулам	
13	Хамтын сангийн зарцуулах, тайлагнах журмыг хамт олны хурлаар хэлэлцэн батлана.	1 сард	Л.Дуламсүрэн М.Пүрэвдулам	

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
НЯГТЛАН БОДОГЧ



Л.ДУЛАМСҮРЭН

Нормативт зардал	1500000	0	375000	0	375000	0	0	375000	0	0	375000	0	0
Хоол	1500000	0	375000	0	375000	0	0	375000	0	0	375000	0	0
Эд хогшил, урсгал засварын зардал	4000000	4000000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тавилга	2000000	2000000											
Урсгал засвар	2000000	2000000		0				0					
Томиллолт, зочны зардал	6000000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000
Дотоод албан томиллолт	6000000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000	500000
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6600000	0	1500000	600000	0	1500000	0	0	1500000	0	1500000	0	0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6000000	0	1500000	0	0	1500000	0	0	1500000	0	1500000	0	0
Даатгалын үйлчилгээ	250000	0	0	250000	0	0	0	0	0	0	0	0	0
Тээврийн хэрэгслийн татвар	200000	0	0	200000	0	0	0	0	0	0	0	0	0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	50000	0	0	50000	0	0	0	0	0	0	0	0	0
Газрын төлбөр	100000	0	0	100000	0	0	0	0	0	0	0	0	0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	773900		773900										
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1500000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	1500000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000	125000
Төсвөөс санхүүжих	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Байгууллагын тоо	1												
Ажиллагсад бүгд	13												
Удирдах ажилтан	1												
Гүйцэтгэх ажилтан	8												
Үйлчлэх ажилтан	4												